ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр Дугаар А/43 Арвайхээр сум

М.Чулууны газар эзэмших эрхийг
Л.Түмэндэмбэрэлд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмшигчийн гаргасан хүсэлтийн дагуу тус сумын Дэлгэрэх 3 дугаар багийн 2 дугаар гудамжны 5 тоотод байрлах Магсарын Чулууны эзэмшлийн 6216034537 нэгж талбарын дугаартай, 9 жилийн эрхийн гэрчилгээний хугацаатай, 1322 м2 хэмжээ бүхий худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай газар эзэмших эрхийг Ламзавын Түмэндэмбэрэлд шилжүүлсүгэй.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны “Газар эзэмшлийн эрх шилжүүлэх тухай” А/90 дүгээр захирамжийн М.Чулуунтай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Дээрх газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцсон татварын баримт болон газрын эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг Газрын даамал (Ш.Адъяадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2024/Alban bichig/Zahiramj-2024

522411107